



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХК-ИЙН 2024 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СНАГ-2025/06/НА-СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Санхүү-Нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261883 Цахим хаяг: naranchimeg1s@audit.gov.mn
Аудитын менежер: П.Чанцалдулам
Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamj@audit.gov.mn
Ахлах аудитор: Ж.Нямцэцэг
Утас: 51-261740 Цахим хаяг: nyamtsetsegi@audit.gov.mn
Грант торитон аудит ХХК-ийн Ерөнхий захирал: Б.Осоргарав
Утас: 99113795 Цахим хаяг: info@mn.gt.com

Улаанбаатар хот
2025 он



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160.
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ"
ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Б.ДӨЛГӨӨН ТАНАА

2025.03.17 № 07/1070
танай _____-ны № _____-т

Сөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд аж ахуйн нэгж болон хуулийн этгээдүүд нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор журмын дагуу нийт 767,771.2 сая төгрөгийн дэнчинг байршуулснаас арилжаанд ялсан 726,657.0 сая төгрөгийн битүүмжлэгдсэн дэнчин, 41,114.2 сая төгрөгийн идэвхтэй дэнчин "Монголын Хөрөнгийн Бирж ХК"-ийн харилцах дансанд байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд нийт орлогыг 37,076.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 9,640.1 сая төгрөгөөр баталж, 2,703.1 сая төгрөгийн татварын зардал тооцож, 24,328.1 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажиллахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 46,661.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 8,586.1 сая төгрөг зарцуулж, орлогын албан татварын зардалд 3,799.1 сая төгрөгийг тайлагнаж, 34,176.6 сая төгрөгийн татварын дараах ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 4 дүгээр сарын 9-ны өдрийн 19 дугаар тогтоолоор компанийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг "Хангалттай" гэж дүгнэсэн байна. 2024 оны 5 дугаар сарын 2-ны өдөр Төлөөлөн удирдах зөвлөлийн даргын хянаж баталгаажуулсан Компанийн 2023 оны засаглалын кодексийн хэрэгжилтийн тайлангийн дүгнэлт нь 100.0 хувь, хэвийн буюу эрсдэлгүй гэж заасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	902,582,814,516.91	816,117,554,232.94
1.1.2	Дансны авлага	1,868,454,950.77	836,933,524.46
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,457,509.01	34,072,853.11
1.1.4	Бусад авлага	149,471,451.41	2,148,534,565.92
1.1.6	Бараа материал	36,053,729.65	47,311,807.77
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	204,642,999.30	30,693,452.28
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	904,842,895,157.05	819,315,100,436.48
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,453,061,929.98	7,328,148,183.23
1.2.2	Биет бус хөрөнгө	16,998,953,543.12	17,044,540,713.61
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	22,452,015,473.10	24,372,688,896.84
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	927,294,910,630.15	843,687,789,333.32
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	265,821,383.36	91,733,714.37
2.1.1.2	Цалингийн өглөг	612,117.37	5,815,835.99
2.1.1.3	Татварын өглөг	341,303,910.22	235,985,175.46
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	17,955,656.95	109,442,220.57
2.1.1.12	УУБ-ны арилжааны дэнчинд байршиж буй мөнгө	880,962,845,181.82	767,771,156,772.44
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	881,588,538,249.72	768,214,133,718.83
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.2	Нөөц /өр төлбөр/	635,862,600.00	635,862,600.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	990,698,992.92	928,380,130.26
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	1,626,561,592.92	1,564,242,730.26
2.2	Өр төлбөрийн нийт дүн	883,215,099,842.64	769,778,376,449.09
2.3	Эздийн өмч	35,046,353,900.00	35,046,353,900.00
2.3.1	а) төрийн	23,130,593,600.00	23,130,593,600.00
2.3.3	в) хувьцаат	11,915,760,300.00	11,915,760,300.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	20,021,146,332.29	20,005,435,662.81
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	446,321,902.02	446,321,902.02
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,434,011,348.80)	18,411,301,419.40
2.3.11	Эздийн өмчийн дүн	44,079,810,787.51	73,909,412,884.23
2.4	ӨР ТӨЛБӨР ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	927,294,910,630.15	843,687,789,333.32

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	12,147,031,303.89	13,521,664,119.64
2	Борлуулалтын өртөг	-	5,166,647,083.45
3	Нийт ашиг	12,147,031,303.89	8,355,017,036.19
5	Хүүний орлого	4,562,440,335.78	33,116,453,514.06
8	Бусад орлого	13,170,675.00	23,649,812.00
9	Борлуулалт маркетингийн зардал	186,062,107.06	671,207,509.55
10	Ерөнхий ба удирдлагын зардал	5,992,598,429.63	2,624,904,971.74
12	Бусад зардал	19,748,469.36	123,399,481.77
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз /гарз/	(186,717,492.52)	(99,547,103.77)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	(196,590.99)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг	10,337,515,816.10	37,975,864,704.43
19	Орлогын татварын зардал	1,029,799,778.87	3,799,182,441.16
20	Татварын дараах ашиг	9,307,716,037.23	34,176,682,263.27
22	Тайлант үеийн цэвэр ашиг	9,307,716,037.23	34,176,682,263.27
23	Бусад дэлгэрэнгүй орлого	-	-
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
23.3	Бусад олз /гарз/	-	-
24	Орлогын нийт дүн	9,307,716,037.23	34,176,682,263.27

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмч	Дахин үнэлгээний нөөц	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,105,864,784.03)	23,492,197,050.28
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(635,862,600.00)	(635,862,600.00)
Залруулсан үлдэгдэл	23,130,593,600.00	20,021,146,332.29	446,321,902.02	(20,741,727,384.03)	22,856,334,450.28
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	9,307,716,037.23	9,307,716,037.23
Өмчид гарсан өөрчлөлт	11,915,760,300.00	-	-	-	11,915,760,300.00
2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,434,011,346.80)	44,079,810,787.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	38,117.87	38,117.87
Залруулсан үлдэгдэл	35,046,353,900.00	20,021,146,332.29	446,321,902.02	(11,433,973,228.93)	44,079,848,905.38
Тайлант үеийн цэвэр ашиг	-	-	-	34,176,682,263.27	34,176,682,263.27
Зарласан ногдол ашиг	-	-	-	4,349,252,518.99	4,349,252,518.99
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(15,710,689.48)	-	17,544,904.05	2,134,234.57
2024 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	35,046,353,900.00	20,005,435,662.81	446,321,902.02	18,411,301,419.40	73,909,412,884.23

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	1,441,824,632,647.89	2,326,735,166,461.15
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	11,595,182,149.63	15,877,265,204.60
1.1.3	Даатгалын нөхөрөөс хүлээн авсан мөнгө	6,128,434.00	14,355,955.00
1.1.7	Хүлээн авсан хүүний орлого	4,413,827,379.90	31,119,193,464.18
1.1.9	Бусад мөнгөн орлого	1,425,809,494,684.36	2,279,724,351,837.37
1.2	Мөнгөн зарлагын дүн	544,905,224,391.89	2,410,500,737,760.85
1.2.1	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	238,000,000.00	-
1.2.2	Ажиллагчдад төлсөн	1,778,266,221.02	2,914,157,156.16
1.2.3	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	512,421,844.47	826,171,873.76
1.2.4	Бараа материал худалдан авахад төлсөн	41,110,050.00	63,964,460.50
1.2.5	Ашиглалтын зардалд төлсөн	111,522,685.60	85,682,299.14
1.2.6	Түпш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	1,758,400.00	991,960.00
1.2.8	Татварын байгууллагад төлсөн	2,058,142,678.97	5,486,589,832.72
1.2.9	Даатгалын төлбөрт төлсөн	5,000,000.00	5,106,920.00
1.2.10	Зохицуулалтын хөлс, шимтгэл хураамжид төлсөн	566,128,324.18	806,790,916.87
1.2.11	Бусад мөнгөн зарлага	539,592,874,187.65	2,400,311,282,341.70
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	896,919,408,256.00	(83,765,571,299.69)
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	-	4,500,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	4,500,000.00
2.2	Мөнгөн зарлагын дүн	575,344,268.00	3,165,764,932.69
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	347,651,580.00	2,343,657,781.80
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	227,692,688.00	822,107,150.89
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(575,344,268.00)	(3,161,264,932.69)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн	11,915,759,800.00	-
3.1.2	Хувьцаа болон өмчийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	11,915,759,800.00	-
3.2	Мөнгөн зарлагын дүн	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	11,915,759,800.00	-

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл...)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Төгрөгөөр)

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 сарын 31	2024 оны 12 сарын 31
4	Валютын ханшийн зөрүү	(7,408,719,094.28)	461,575,948.40
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	900,851,104,693.72	(86,465,260,283.98)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,731,709,823.19	902,582,814,516.91
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	902,582,814,516.91	816,117,554,232.93

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл
2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он			
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/	Хувь
I (А+Б)	НИЙТ ОРЛОГО	16,722,642.3	37,076,055.2	46,661,767.4	9,585,712.2	125.9
А	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	12,160,202.0	13,061,718.8	13,545,313.9	483,595.1	103.7
1	Хувьцааны арилжааны шимтгэл	2,464,641.7	2,422,215.8	2,009,563.5	(412,652.3)	83.0
2	Бондын арилжаваны шимтгэл	91,084.1	615,863.9	1,079,234.1	463,370.2	175.2
3	ХОС-ын нэгж эрх арилжааны шимтгэл	42,744.5	109,238.5	224,932.6	115,694.1	205.9
4	Нүүрсний арилжааны шимтгэл	6,678,704.5	7,399,012.9	7,506,273.5	107,260.6	101.4
5	Төмөр жоншны арилжаваны шимтгэл	176,516.7	501,626.0	524,816.8	23,190.8	104.6
6	Зэс арилжааны шимтгэл	-	153,711.3	36,818.8	(116,892.5)	24.0
7	Гишүүнчлэлийн жилийн хураамж	109,282.2	80,940.0	108,590.9	27,650.9	134.2
8	Терминал ашигласны хураамж	63,411.0	72,540.0	66,836.4	(5,703.6)	92.1
9	Үнэт цаас бүртгэх үйлчилгээний орлого	1,861,852.6	424,400.0	539,022.1	114,622.1	127.0
10	УУБ бүртгэх үйлчилгээний хөлс	-	390,620.6	558,454.5	167,833.9	143.0
11	Бүртгэлтэй компанийн жилийн хурвамж	391,385.3	517,293.5	493,864.1	(23,429.4)	95.5
12	Сургалтын орлого	8,181.8	43,200.0	11,809.1	(31,390.9)	27.3
13	Мэдээллийн үйлчилгээний орлого	163,918.7	250,856.5	208,990.5	(41,866.0)	83.3
14	Бусад орлого	108,478.9	80,200.0	176,107.1	95,907.1	219.6
Б	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	4,562,440.3	24,014,336.3	33,116,453.5	9,102,117.2	137.9
1	Хүүгийн орлого	4,562,440.3	24,014,336.3	33,116,453.5	9,102,117.2	137.9
В	НИЙТ ЗАРДАЛ	6,198,408.7	9,840,412.9	8,586,158.6	(1,254,254.3)	87.3
1	Ажилтнуудын цалин хөлс	2,058,917.4	3,457,573.0	3,274,128.2	(183,444.8)	94.7
2	НДШ-ийн зардал	256,963.0	466,772.0	406,734.0	(60,038.0)	87.1
3	Удирдлагын зардал	152,809.5	442,354.0	394,458.4	(47,895.6)	89.2
4	Материал, бичиг хэрэг	31,779.0	46,872.0	32,022.7	(14,849.3)	68.3
5	Харилцаа холбооны зардал	7,709.4	11,215.8	8,628.4	(2,587.4)	76.9

2.6 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл (үргэлжлэл...)

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

(Мянган төгрөгөөр)

№	Үндсэн үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 он			
			Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэтрэлт /хэмнэлт/	хувь
6	Интернет ашиглалт	15,483.9	18,640.9	12,659.3	(5,981.6)	67.9
7	Программ хангамж ашиглалтын зардал	-	15,840.0	6,653.0	(9,187.0)	42.0
8	Шатахуун, тээврийн хэрэгслийн зардал	1,705.4	11,258.0	-	(11,258.0)	0.0
9	Урсгал засвар	23,510.0	54,512.8	31,866.6	(22,646.2)	58.5
10	Цахилгаан, дулаан, ус, хог	54,907.3	74,523.0	48,819.6	(25,703.4)	65.5
11	Албан томилолт	35,085.7	254,276.0	131,863.6	(122,392.4)	51.9
12	Сургалт семинар	28,524.6	201,650.2	118,478.4	(83,171.8)	58.8
13	Ажилтнуудын нийгэм, соёлын зардал	4,465.0	144,230.0	95,132.8	(49,097.2)	66.0
14	ЗЗ идэвхжүүлэлт, бизнес харилцааны зардал	47,300.4	199,000.0	117,083.7	(81,916.3)	58.8
15	ХЭХ зохион байгуулалтын зардал	37,760.4	80,000.0	9,542.9	(50,457.1)	15.9
16	Мэдээлэл технологийн зардал	88,947.4	113,451.0	100,116.2	(13,334.8)	88.2
17	Мэдээллийн үйлчилгээний зардал	-	53,985.0	-	(53,985.0)	0.0
18	Бусад зардал	74,675.2	122,719.0	116,734.7	(5,984.3)	95.1
19	ҮХХ-ийн татварын зардал	-	28,550.0	24,301.8	(5,248.2)	82.2
20	Элэгдлийн зардал	609,065.7	900,532.5	679,631.7	(220,900.8)	75.5
21	Зохицуулах үйлчилгээний хөлс /СЗХ/	704,567.0	1,120,166.8	1,138,052.7	17,885.9	101.6
22	Систем ашиглалтын зардал:	1,726,232.5	1,853,017.5	1,688,723.0	(164,294.5)	91.1
	Үүнд: Системийн элэгдлийн зардал	684,335.7	684,335.7	684,335.7	-	100.0
	Системийн жилийн үйлчилгээний зардал	1,041,896.8	1,168,681.8	1,004,387.0	(164,294.8)	85.9
23	Зөвлөх үйлчилгээний зардал	238,000.0	136,000.0	132,780.0	(3,220.0)	97.6
24	Болзошгүй зардал	-	52,273.4	17,727.3	(34,546.1)	33.9
Г	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ АШИГ АЛДАГДАЛ	10,524,233.6	27,235,642.3	38,075,608.8	10,839,966.5	139.8
Д	Олз/гарз	(186,717.0)	(204,417.4)	(99,743.7)	104,673.7	48.8
Е	ТАТВАРЫН ӨМНӨХ ЦЭВЭР АШИГ (Г+Д)	10,337,516.6	27,031,224.9	37,975,865.1	10,944,640.2	140.5

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани түүний үйл ажиллагаа

"Монголын Хөрөнгийн Бирж" ХК нь Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг сэргээн хөгжүүлэх дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг идэвхжүүлэх, дэмжин урамшуулахад үйл ажиллагаагаа чиглүүлж, үнэт цаасны зах зээлийг дотоодын болон дэлхийн зах зээлд хөгжүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг нээлттэй ил тод зохион байгуулах зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулах чиг үүрэгтэй Сангийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Компанийн улсын бүртгэлийн гэрчилгээнд "Хувьцаат компани" гэсэн статустай, өмчийн нийт хувьцааны 66 хувийг Сангийн яам, үлдсэн 34 хувийг олон нийт эзэмшдэг байна.

Компани нь 1991 оны 01 дүгээр сарын 18-ны өдөр байгуулагдсан цагаасаа эхлэн үнэт цаасны арилжааны биржийн үйл ажиллагаа эрхэлсэн. Өмнөх онд нүүрс болон төмрийн уул уурхайн бүтээгдэхүүнийг биржээр арилжаалж эхэлсэн бөгөөд 2024 онд бизнесээ өргөжүүлж жонш болон зэсийн бүтээгдэхүүнийг арилжаалж эхэлсэн байна.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийн дагуу "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам" боловсруулан 2023 оны 6 дугаар сарын 26-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор батлан, мөрдөж тайлант жилд тасралтгүй уул уурхайн арилжааг хэвийн явуулсан байна.

Тайлант жилд дуудлага худалдаагаар 8,276.040.8 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 22,368 мянган тонн нүүрс, 567,767.9 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 2,425.5 мянган тонн төмөр, 9,982.9 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 17.6 мянган тонн жонш, 40,500.7 сая төгрөгийн хэлцлийн үнийн дүнтэй 6 мянган тонн зэс амжилттай биржээр арилжаалагдсан байна.

3.2 Компанийн гадаад, дотоод орчин

"Монголын Хөрөнгийн Бирж" ХК-ийг Монгол Улсын Засгийн газрын 1991 оны 22 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд "Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..." гэсэн заалттай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнийг хувьцаа эзэмшигчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэгч Засгийн газар томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7-д "Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусвар болгох", Компанийн удирдлагыг Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор томилж байгаа нь компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 1.8-д "Компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох" гэсэн заалтуудтай нийцэж байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 1,300.0 мянган төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7-д "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн

этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Компани нь Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичгийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

Тайлант хугацаанд компанийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт өөрчлөлт;
- ТУЗ-ийн 2024 оны 278 дугаар тушаалаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг";
- ТУЗ-ийн 2024 оны 24 дүгээр тушаалаар баталсан "Дотоод аудитын журам";
- ТУЗ-ийн 2024 оны 40 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журам";
- ТУЗ-ийн 2024 оны 40 дүгээр тушаалаар шинэчлэн баталсан "Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх мэдээллийн журам";
- ТУЗ-ийн 2024 оны 55 дугаар тушаалаар баталсан "Цалин урамшууллын хорооны үйл ажиллагааны журам";
- ТУЗ-ийн 2024 оны 56 дугаар тушаалаар шинэчлэн баталсан "Мөнгөн хөрөнгийн удирдлагын дотоод журам";
- ТУЗ-ийн 2024 оны 57 дугаар тушаалаар баталсан "Эрсдэлийн сангийн журам".

Компанийн удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Дотоод аудитын алба нь хорооны дарга, чиглэл хариуцсан 2 аудиторын бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. Гүйцэтгэх захирлын 2016 оны 167 дугаар тушаалаар баталсан "Дотоод хяналт шалгалтын журам"-ыг мөрдөж ажилладаг.

Тайлант жилд Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 15 дугаар тогтоолоор батлагдсан Дотоод аудитын төлөвлөгөөнд хууль эрх зүйн нийцлийн, мэдээлэл технологийн, цалингийн, бизнес төлөвлөгөөний гэсэн нийт 4 зорилтот аудитын ажил тусгагдсан бөгөөд шалгалтын хүрээнд нийт 132 зөвлөмж өгснөөс 88 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж, 24 зөвлөмж хэрэгжиж шатанд, 20 зөвлөмжийн хэрэгжих нөхцөл бүрдээгүй тул хойшлуулсан байна.

Дотоод аудитын албаны чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн санхүүгийн тайлангийн талаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг судлах аудитын горим хэрэгжүүлснээр Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулсан гэж үнэлсэн. Энэхүү зааварт хөрөнгө өр төлбөр, орлого зардлын хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэхийг шаарддаг хэдий ч, СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй байна.

Монголын Хөрөнгийн Бирж ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус компани нь “Мишээл-Од Аудит” ХХК-иар боловсруулсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдрийн 278 дугаар тогтоолоор батлуулж, тайлант оноос мөрдөж эхэлсэн байна.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн боловч үйл ажиллагааны онцлогт тохироогүй байна. Тайлант жилд компани нь “зардлын чиг үүрэг” буюу “борлуулалтын өртөг”-ийн аргаар орлогын дэлгэрэнгүй тайланг бэлтгэсэн боловч энэхүү арга нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдаагүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Компанийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар баталсан аж ахуйн нэгжид мөрдөгдөх “Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 83,607.1 сая төгрөгөөр буюу 9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

(мянган төгрөгөөр)			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	902,582,814.5	816,117,554.2	(86,465,260.3)
Авлага	2,019,384.0	3,119,541.0	1,100,157.0
Бариа материал	36,053.7	47,311.8	11,258.2
Урьдчилж төлсөн зардал	204,643.0	30,693.5	(173,949.5)
Үндсэн хөрөнгө	22,452,015.4	24,372,688.8	1,920,673.5
Нийт хөрөнгө	927,294,910.6	843,687,789.3	(83,607,121.3)
Өр төлбөр	883,215,099.8	769,778,376.4	(113,436,723.4)
Эздийн өмч	44,079,810.8	73,909,412.9	29,829,602.1
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	927,294,910.6	843,687,789.3	(83,607,121.3)

Тайлант онд нөлөө бүхий өөрчлөлт гарсан дараах данстууд байна. Үүнд,

Мөнгөн хөрөнгө: Тайлант жилийн татварын дараах цэвэр ашиг нь 34,176.7 сая төгрөг байгаа боловч мөнгөн хөрөнгө нь 86,465.3 сая төгрөгөөр буурсан шалтгаан нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжааны дэнчинг оролцогч талуудад буцаан олгосонтой холбоотойгоор 113,191.7 сая төгрөгөөр дэнчингийн үлдэгдэл буурч, 818.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Авлага: Тайлант жилийн авлагын үлдэгдлийн 69 хувь буюу 2,148.5 сая төгрөгийг банкны хүүгийн авлага эзэлж байна. Тайлант жилд авлага барагдуулалт сайжирч харилцах дансны төгрөгийн үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого өссөнтэй холбоотойгоор авлага өсөж, 3,119.5 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Урьдчилж төлсөн зардал: Тайлант жилд Лондонгийн хөрөнгийн биржид систем хөгжүүлэлтийн урьдчилж төлсөн төлбөр 137.5 сая төгрөг, гэрээгээр гүйцэтгэж байгаа ажил үйлчилгээ бүрэн хэрэгжиж тайлант хугацааны зардлаар бүртгэснээс үлдэгдэл буурсан.

Үндсэн хөрөнгө: Үндсэн хөрөнгийн данс 1,920.7 сая төгрөгөөр өссөн нь тайлант жилд компани өөрийн эзэмшлийн барилгад 1,671.7 сая төгрөгийн их засварын ажил хийж, биет бус хөрөнгийн сайжруулалтад 1,018.3 сая төгрөгийг бүртгэж, 437.8 сая төгрөгийн тавилга, эд хогшил болон тоног төхөөрөмж, үйл ажиллагаанд зориулж 161.0 сая төгрөгийн жижиг оврын тазарийн хэрэгслийг худалдан авснаар тус тус нэмэгдэж, 257.6 сая төгрөгийн хөрөнгө актлж, 1,110.6 сая төгрөгийн элэгдлийн зардал байгуулснаа буурсан байна.

Өр төлбөр: ААН болон хуулийн этгээдүүд нь уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор журмын дагуу тайлант жилд нийт 2,297,706.1 сая төгрөгийн дэнчин байршуулсан ба үүнээс 2,410,897.0 сая төгрөгийг арилжаанд оролцогч талууд руу буцаан олгосноор нийт өр төлбөрийн дүн буурсан байна.

Эздийн өмч: Тайлант жилд 29,829.6 сая төгрөгөөр өссөн нь банкны хүүгийн орлого өмнөх оноос 28,554.0 сая төгрөгөөр нэмэгдсэн, тайлант онд 24,868.9 сая төгрөг ашигтай ажилласан зэргээс голлон нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу “Монголын хөрөнгийн бирж” ХК хөрөнгө оруулалт болон эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний төлөвлөгөөг боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 5 дугаар сарын 22-ны өдрийн 28 дугаар тогтоолоор 2024 оны орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна.

Дээрх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор тодотгож, тайлант оны нийт орлогыг 37,076.1 сая төгрөгөөр, нийт зардлыг 9,840.4 сая төгрөгөөр баталж, 2,702.1 сая төгрөгийн татварын зардал тооцож, 24,328.1 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар төлөвлөсөн байна.

Эдийн засгийн зорилтот түвшнийг батлуулахдаа компанийн үйл ажиллагааны онцлогт тохируулан орлого, зардлын үзүүлэлт тус бүрээр батлуулдаг байна. Компанийн ТУЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 54 дүгээр тогтоолоор 2024 оны бизнес төлөвлөгөөг боловсруулан батлуулсан, тус төлөвлөгөөнд компанийн ашигт ажиллагааг нэмэгдүүлэн ажиллах дараах зорилтыг тавин ажилласан байна. Үүнд:

- Нийт орлогыг 29.0 хувиар нэмэгдүүлэх
- Цэвэр ашгийг 23.9 хувиар нэмэгдүүлэх
- Нийт 462,500 сая үнэлгээ бүхий 21 шинэ үнэт цаасыг бүртгэн 424.4 сая төгрөгийн нийт 22.3 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүн бүртгэх зорилтууд байна.

Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин

Гүйцэтгэлээр 46,661.7 сая төгрөгийн орлого бүрдүүлж, нийт зардалд 8,586.1 сая төгрөг, орлогын албан татварын зардалд 3,799.2 сая төгрөгийг тайлагнаж, 34,176.7 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан байна. Нийт орлого 9,585.7 сая төгрөгөөр нэмэгдсэн нь дэнчингийн харилцах дансны үлдэгдэлд тооцсон хүүгийн орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардлын гүйцэтгэл 8,586.2 сая төгрөг болж, төлөвлөснөөс 1,254.3 сая төгрөгийг зарцуулаагүй байна. Үүнээс, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 29-ны өдрийн 22 дугаар тогтоолоор 72 ажилтны орон тоо баталснаас 2024 онд 70 ажилтантай ажиллаж, цалин хөлсийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгож, 243.5 сая төгрөг, албан томилолт, сургалт, уулзалтыг цахимаар хийх арга хэмжээ авч 336.6 сая төгрөг, арилжааны системийн ашиглалтын болон элэгдлийн зардлаас 385.2 сая төгрөгийг тус тус хэмнэжээ.

Хөрөнгө оруулалтаар нийт 39 нэр төрлийн ажил үйлчилгээ явуулахаар 1,102.0 сая төгрөг төлөвлөснөөс 994.7 сая төгрөгийн 28 ажил үйлчилгээний тендер сонгон шалгаруулалт амжилттай зарлагдаж, 90.3 хувийн гүйцэтгэлтэйгээр хэрэгжиж байна.

Хүснэгт 2. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний гүйцэтгэл (Мянган төгрөгөөр)

Үндсэн үзүүлэлт	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Хэтрэлт/хэмнэлт	Хувь
Үндсэн хөрөнгө:				
Барилга, байгууламж	219,823.7	219,823.7	-	100.0
Тавилга эд хогшил	95,206.7	84,236.3	10,970.5	88.5
Биет бус хөрөнгө	339,488.8	255,094.5	84,394.3	75.1
Тээврийн хэрэгсэл	161,000.0	161,000.0	-	100.0
Тоног төхөөрөмж	286,498.8	274,509.0	11,989.8	95.8
Нийт дүн	1,102,018.0	994,663.5	107,354.6	90.3

*Нөөц дата төв түүний тоног төхөөрөмжийн шинэчлэл-ийн ажлын дагуу “MIT” арилжааны систем нийлүүлэгч талаас ирүүлсэн эхний шаардлагаар 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд уг ажлын хүрээнд өгөгдлийн сангийн зохион байгуулалтын өөрчлөлтөөс хамааран Oracle Linux OS, Oracle 19-ийн лицензүүдийг ашиглах шаардлагагүй болж 75.4 сая төгрөг зарцуулагдаагүй байна. Харин Microsoft office 365 лицензийг цахим дэлгүүрт урилга хүргүүлэн бага үнийн дүнтэй нийлүүлэгчийг сонгосноор 5.2 сая төгрөгийг хэмнэсэн бол 3.8 саяын өртөгт Adobe үүлэн системийн жилийн эрх авах худалдан авалтыг хийгээгүйгээс биет бус хөрөнгийн төсвийн гүйцэтгэл 75.1 хувьтай хэрэгжсэн байна.

Тавилга эд хогшлын төсвөөс сейф, архивын тавцант тавиур, гар ачааны тэрэг зэрэг 6.5 сая төгрөгийн худалдан авалт хийгдээгүй бол бусад эд хогшлыг үндсэн төсөвт өртгөөс 4.5 сая төгрөгөөр бага дүнгээр худалдан авч хэмнэлт үүсгэсэн байна.

Харин тоног төхөөрөмжийн төсвийн халаагуур тенд, цахилгаан дрилл, агаар цэвэршүүлэгчид төсөвлөсөн 3.8 сая төгрөг зарцуулагдаагүй үлдэж, 8.1 сая төгрөгийг бусад төхөөрөмжийн худалдан авалтаас хэмнэж ажилласан байна. Үүнээс дүгнэхэд зарим хөрөнгө, эд зүйлсийг

үнэлэхдээ зах зээлийн бодит үнээр төсөөт тусгах, үйл ажиллагаанд чухал хэрэгцээт бус худалдан авалт хийгдэхгүй эд зүйлсийг төсөөт оруулахгүй байх тал дээр анхаарч ажиллан үнэн зөв төсвийг мөрдөн ажиллах шаардлагатай гэж үзэв.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу “Монголын Хөрөнгийн Бирж ХК”-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн компани, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Грант Торнтон Аудит ХХК-ийн ахлах аудитор Г.Анужин, аудитор Б.Энхцэцэг, туслах аудитор Э.Наранжаргал нар гүйцэтгэж, аудитын менежер Л.Болорцэцэг, чанарын хяналтын партнер Н.Эрдэнэцог, гэрээт ажлын партнер О.Идшинринжин нар анхан шатны чанарын хяналтыг, Санхүү, нийцлийн аудитын газрын ахлах аудитор Ж.Нямцэцэг, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

“Монголын Хөрөнгийн Бирж” ХК нь 2024 оны санхүүгийн тайлангаа Үндэсний аудитын газарт 2024 оны 02 дугаар сарын 7-ны өдрийн 112 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр “Нийт орлого”-ийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны 12 дугаар сарын 31-нээрх орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт орлого 16,722.6 сая төгрөгөөс 1 хувиар буюу 167.2 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжээж эхэлсэнтэй холбоотойгоор компани зайлшгүй шаардлагатайгаас бусад хангамж, оффисын зардлыг бууруулах арга хэмжээ авсан мөн хуулийн хүрээнд албан томилолт, сургалт уулзалтыг цахимжуулах арга хэмжээ авч 171.5 сая төгрөг, цалин хөлсийг ажлын гүйцэтгэлтэй уялдуулан олгож 243.4 сая төгрөгийг тус тус хэмнэж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг шалгахад мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод, бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгадагч байгууллагын 2024 оны 3 улирлын санхүүгийн тайланг хамруулж, балансын бүх дансдын хувьд горим, сорил хэрэгжүүлсэн.

Тайлант оны 9 дүгээр сарын 30-наар тасалбар болгон бэлтгэсэн санхүүгийн тайланд хийсэн завсрын аудитаар 91.8 сая төгрөгийн 4 алдаа, зөрчил илэрснээс 91.8 сая төгрөгийн 1 залруулах зөвлөмж, давтан гаргахгүй байх 3 зөвлөмжийг асуудлын бүртгэлээр шалгадагч компанид танилцуулан баталгаажуулж, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар хэрэгжилтийг шалгахад 98.3 хувь хэрэгжүүлж ажилласан байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар тогтоосон 1.8 сая төгрөгийн 2 төлбөрийн акт, хүргүүлсэн 56.1 сая төгрөгийн 8 албан шаардлага, 2,543.2 сая төгрөгийн 7 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

(мянгаан төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	2	1,834.9	2	1,834.9	100.0
Албан шаардлага	8	56,098.3	8	56,098.3	100.0
Зөвлөмж	7	2,543,216.2	7	2,543,216.2	100.0
Нийт дүн	17	2,601,149.4	17	2,604,149.4	100.0

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар компанийн мөрдөж ажилладаг зохицуулах хорооноос гаргасан, дотооддоо боловсруулсан дүрэм журмууд нь байгууллагын онцлогт нийцсэн байдлыг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,186.2 сая төгрөгийн 4 алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Залруулсан алдаа: НББОУС-8 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа стандартын 41-д "...тайлант үед илрүүлсэн уг тайлант үеийн боломжит алдааг тухайн үеийн тайланг гаргахыг зөвшөөрөхөөс өмнө засварладаг...", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөлтөд гарсан алдааг алдаа гарсан шалтгаан, залруулах аргыг тодорхой тусгасан баримт, тайланг үндэслэн залруулах бөгөөд зөвшөөрсөн болон залруулга хийсэн албан тушаалтан гарын үсэг зурж баталгаажуулна", 15.2-т "нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж тус тус заасны дагуу дараах залруулгыг хийсэн. Үүнд:

- ХОС-ын нэгжийн эрх арилжааны шимтгэл 46.3 сая төгрөг, компанийн бондын арилжааны шимтгэл 459.8 сая төгрөг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааны шимтгэл 53.5 сая төгрөг, нийт 559.6 сая төгрөгийг хувьцааны арилжааны шимтгэл дансанд ангилал зөрүүтэй бүртгэснийг;
- Ерөнхий ба удирдлагын зардал 205.5 сая төгрөгийг борлуулалтын өртөг дансанд буруу тайлагнасныг;
- Ерөнхий ба удирдлагын зардал 25.6 сая төгрөгийг борлуулалт, маркетингийн зардлаар ангилал буруу тайлагнасныг;
- Харилцах дансны хүүгийн орлогын 395.5 сая төгрөгийг бусад мөнгөн орлого дансанд ангилан буруу тайлагнасныг тус тус залруулсан.

Аудитаар нийт 753.6 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 67.1 сая төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага, 686.5 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

1. Уул уурхайн бүтээгдэхүүний дэнчинтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант хугацаанд Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор дэнчин байршуулсан хуулийн этгээдүүдийн мөнгөн дэнчинг хуулийн этгээдээс албан санал хүсэлт ирүүлээгүй байхад нь дараагийн арилжаанд оруулж байгаа нь МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 19 дүгээр тогтоолоор баталсан Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаа, төлбөр тооцоог гүйцэтгэхэд баримтлах журмын 5.9-д "Худалдан авах санал гаргагчийн цахимаар ирүүлсэн албан ёсны хүсэлтээр дэнчинг дараагийн арилжаанд оролцох зорилгоор Биржийн дансанд хэвээр үлдээж болино" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Хуулийн этгээдээс албан санал хүсэлт ирүүлээгүй байхад мөнгөн дэнчинг дараагийн арилжаанд оруулж байгаа зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Бүртгэлтэй хувьцаат компаниудын асуудал

Илрүүлэлт: Хувьцаат компаниудын ангилал, зэрэглэлийн мэдээллийг тухай бүр шинэчлээгүй, нэг жилээс дээш үйл ажиллагаа явуулаагүй, идэвхгүй хувьцаат компаниудыг

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, гэмдэглээгүй орхисон/.

биржийн бүртгэлээс хасаагүй нь МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 5 дугаар сарын 10-ны өдрийн 9 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 23 дугаар бүлэг "Бирж нь дараах тохиолдолд үнэт цаасыг Биржийн бүртгэлээс хасна", 23.11.3-т "Бүртгэлтэй байх хугацаанд тогтмол биелүүлэх үүрэг болон хууль, дүрэм, журам, гэрээгээр хүлээсэн үүргээ удаа дараа биелүүлээгүй, жилийн үйлчилгээний хөлсийг 2 жилээс дээш хугацаанд төлөөгүй", 23.11.4-д "Үнэт цаасны арилжааг зогсоосноос хойш 1 жилээс дээш хугацаанд арилжаа сэргээгүй буюу арилжааг зогсоох нөхцөл шалтгаан нь арилаагүй" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Хувьцаат компаниудын мэдээллийг тухай бүр шинэчлээгүй, идэвхгүй хувьцаат компаниудыг биржийн бүртгэлээс хасаагүй зэрэг зөрчлийг таслан зогсоож, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Анард ХХК-тай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2011 оны 6 сарын 27-ны өдрийн 1097 дугаар шийдвэрээр "... он дамжсан 67,130,000.00 /жаран долоон сая нэг зуун гучин мянган/ төгрөгийн авлагыг "Анард" ХХК-иас гаргуулж "Монголын Хөрөнгийн Бирж" ХК-д олгохоор шийдвэрлэсэн боловч энэхүү авлагыг өнөөдрийг хүртэл барагдуулах ажиллагаа хийгдээгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6-д "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Шүүхийн шийдвэрийн дагуу "Анард" ХХК-иас гаргуулахаар шийдвэрлэсэн он дамжсан авлагыг барагдуулах ажиллагаа хийгдээгүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Нягтлан Бодох Бүртгэлийн Бодлогын Баримт Бичигт үйлчилгээний өртөгт холбогдох зардал болон НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-ын 103-р заалт "Зардлын чиг үүрэг" буюу "Борлуулалтын өртөг"-ийн арга зэргийг тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана", 19 дүгээр зүйлийн 19.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өртөг тооцооллын арга, холбогдох дансны жагсаалтыг тусгаагүй зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

1. Уул уурхайн эрсдэлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант жилд уул уурхайн биржийн эрсдэлийн сангийн харилцааг зохицуулсан, байгууллагын онцлогт тохирсон журмыг гаргасан боловч батламжлагдаагүйн улмаас эрсдэлийн санг тохируулж бүртгээгүй нь Санхүүгийн Зохицуулах Хорсоны Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа, төлбөр тооцоо хийх ерөнхий журам-ын 6.6-д "Спот, форвард гэрээний арилжааны хувьд бирж нь эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх бөгөөд өөрийн хөрөнгийн 3 хувиар эрсдэлийн санг байгуулна", НББОУС 37 "Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө"-ийн 59-д "Нөөцийг тухайн тайлант үе бүрийн эцэст нягталж шалгах бөгөөд одоогийн хамгийн сайн тооцооллыг тусгахын тулд түүнийг тохируулна" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

НББОУС 37 "Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө"-ийн дагуу эрсдэлийн сан байгуулж, бүртгэж тайлагнах тухай зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 10 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

(Мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Заглуулсан		Заглуулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХОС-ын нэгжийн эрх арилжааны шимтгэл 46.3 сая төгрөг, компанийн бондын арилжааны шимтгэл 459.8 сая төгрөг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжааны шимтгэл 53.5 сая төгрөг, нийт 559.6 сая төгрөгийг хувьцааны арилжааны шимтгэл дансанд ангилал зөрүүтэй бүртгэсэн байна. Аудитын явцад зөвлөмж өгч бүрэн залруулсан.	1	559,595.2			1	559,595.2	1	559,595.2				
Ерөнхий ба удирдлагын зардал 205.5 сая төгрөгийг борлуулалтын өртөг дансанд буруу тайлагнасныг аудитын явцад зөвлөмж өгч бүрэн залруулсан.	1	205,510.9			1	205,510.9	1	205,510.9				
Ерөнхий ба удирдлагын зардал 25.6 сая төгрөгийг борлуулалт, маркетингийн зардлаар ангилал буруу тайлагнасныг аудитын явцад зөвлөмж өгч бүрэн залруулсан.	1	25,637.1			1	25,637.1	1	25,637.1				
Харилцах дансны хүүгийн орлого болох 395.5 сая төгрөгийг бусад мөнгөн орлого дансанд ангилан буруу тайлагнасныг аудитын явцад зөвлөмж өгч бүрэн залруулсан.	1	395,463.7			1	395,463.7	1	395,463.7				
Нийт	4	1,186,206.9			4	1,186,206.9	4	1,186,206.9				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(Мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Анард ХХК-аас авах он дэмжсэн 67.1 сая төгрөгийн авлагыг Сонгинохайрхан дүүргийн шүүхийн 2011 оны 6 сарын 27-ны өдрийн 1097 дугаар шийдвэрээр “Анард” ХХК-аас 67.1 сая төгрөгийг гаргуулахаар тус шийдвэрлэсэн боловч энэхүү авлагыг өнөөдрийг хүртэл барагдуулаагүй, ажиллагаа хийгдээгүй байна.	1	67,130.0			1	67,130.0						
Тайлант жилд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа НББББ-т үйлчилгээний өртөгт холбогдох зардал, НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн тогилуулга”-ын 103-р заалт “зардлын чиг үүрэг” буюу “үйлчилгээний өртөг”-ийн арга зэргийг тусгаагүй байна.	1	-			1	-						
Хувьцаат компаниудын ангилал, зэрэглэлийн мэдээллийг тухай бүр шинэчлээгүй, нэг жилээс дээш үйл ажиллагаа явуулаагүй, идэвхгүй хувьцаат компаниудыг биржийн бүртгэлээс хасваагүйгээс бодит бус хураамжийн авлага хуримтлагдах, олон нийтэд болон хувьцаа эзэмшигчдэд буруу мэдээлэл хүргэх эрсдэлтэй байна.	1	-			1	-						
Тайлант хугацаанд Уул уурхайн бүтээгдэхүүний арилжаанд оролцохоор дэнчин байршуулсан хуулийн этгээдүүдийн мөнгөн дэнчинг хуулийн этгээдээс албан санал хүсэлт ирүүлээгүй байхад нь дараагийн арилжаанд оруулж байна.	1	-			1	-						

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (үргэлжлэл...)

(Мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант жилд уул уурхайн биржийн эрсдэлийн сангийн харилцааг зохицуулсан, байгууллагын өнцлөгт тохирсон журмыг гаргасан боловч батламжлагдаагүйн улмаас эрсдэлийн санг тохируулж бүртгээгүй байна.	1	686,531.7					1	686,531.7				
Нийт	5	753,661.7			4	67,130.0	1	686,531.7				

Утас: +976 51 261585

Факс: +976 11 323266, 324653

Цахим шуудан: info@audit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn

Хаяг: Засгийн газрын IV байр
Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг
Улаанбаатар-15160, Монгол Улс